



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛ,
СТАТИСТИКИЙН ГАЗАР

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ
/2015 он/

Өлгий хот 2016 он

Гарчиг

1.Ойлголт тодорхойлолт, судалгааны товч агуулга	4-6
2.Суурин хүн амын насны бүтэц ажил эрхлэлт	7-8
3.Эдийн засгийн идэвхгүй хүн ам	9-10
4. Баруун бүсийн үзүүлэлтүүдийн зэрэгцүүлэлт	11
5.Хөдөлмөрийн чадваргүй хүн ам, суралцагчид	12-13
6.Хөдөлмөрийн насны хүн ам, их, бага үзүүлэлт	14-15
7.Ажиллагчид,ажиллагсад ЭЗСА	16-19
7.Ажилгүйчүүд, ажилгүйдлийн түвшин	20-22
8.Шинэ ажлын байр, бүтэц	23-24
9.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зарцуулалт	25-27
10.Дүгнэлт	28



Танилцуулгыг хянан, тохиосон:

Х.Бахыт

Танилцуулгыг нэгтгэн боловсруулсан:

Ш.Манзелхан

Санал хүсэлт байвал доорх
хаягаар холбоо барина уу.

Баян-Өлгий аймгийн Улсын бүртгэл, статистикийн газар
Засаг даргын тамгын газрын байр

E-mail: stat-bel@mongol.net

Утас: 7042-24-32 ,7042-23-22

Интернет хаяг: //www.bayan-ulgii.ubseg.gov.mn/

Баян-Өлгий аймгийн Улсын бүртгэл, статистикийн газар

Өлгий хот, 2016 оны 06-р сар

Танилцуулгад орсон үзүүлэлтүүдийн ойлголт, тодорхойлолт, тооцсон аргачлал

Ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхитэй хүн ам - Үндэсний тооцооны системийн хүрээнд, тухайн цаг хугацаанд бүтээгдхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй иргэдийг хамруулна. Эдийн засгийн идэвхитэй хүн ам (ажиллах хүч) -ыг *эдийн засгийн байнгын идэвхтэй хүн ам, эдийн засгийн тухайн үеийн идэвхтэй хүн ам* гэж хоёр ангилна.

Эдийн засгийн идэвхитэй хүн амыг урт хугацаагаар буюу хуанлийн жилээр хэмжигдэх байнгын идэвхитэй хүн ам, нэг долоо хоног буюу нэг өдрийн хугацаагаар хэмжигдэх тухайн үеийн идэвхитэй хүн ам гэсэн хоёр аргаар тодорхойлдог. Энд орсон ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхитэй хүн ам нь “байнгын идэвхи” гэсэн ойлголтонд тулгуурласан ба нөгөө талаар Монгол улсын хуулиар тогтоосон хөдөлмөрийн насны хүрээнд багтах хүн ам тул 2000 оны хүн ам, орон сууцны тооллого, 2002-2003 болон 2006-2007 оны Ажиллах хүчний түүвэр судалгааны үед хэрэглэсэн “тухайн үеийн идэвхи”-ээр тодорхойлсон эдийн засгийн идэвхитэй хүн амаас зөрүүтэй учир тоо нь өөр өөр байгаа болно. Хөдөлмөрийн насны ажил эрхлээгүй, халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлгүй хүмүүс, хөдөлмөрийн насны суралцагчид, хугацаат цэргийн албан хаагчид, хоригдол хүмүүс ажиллах хүчинд хамрагдаагүй болно.

Ажил эрхэлдэг хүн ам буюу ажиллагч гэж цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг хэв шинж (статус)-д хамрагдаж буй иргэнийг хэлнэ. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн долоо хоногт нэгээс дээш цагаар оролцсон бол ажиллагч гэж үзнэ. Аж ахуйн нэгж, байгууллагын орон тоонд ажиллагч, албан бус хөдөлмөр эрхлэгч, гэрээгээр ажил гүйцэтгэгч, улирлын чанартай ажиллагчид, түр ажилтан, бүрэн бус цагаар ажиллагчид мөн ажилтай мөртлөө тодорхой шалтгаанаар (өвчтэй, чөлөөтэй, амралттай г.м) ажиллаагүй хүмүүс хамрагдсан.

Ажилгүйчүүд буюу ажилгүй иргэн – Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрийн насны, хөдөлмөрлөх чадвартай, тухайн хугацаанд ажилгүй байсан, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнийг хэлнэ.

-“ажилгүй байсан” гэж сүүлийн долоо хоногт Хөдөлмөрийн тухай болон Иргэний хуулийн 359 дүгээр зүйлд заасан хөлсөөр болон ажил гүйцэтгэх гэрээгээр ямар нэг ажил гүйцэтгээгүй, хувиараа ажил, үйлчилгээ эрхэлж орлого олоогүй байхыг;

-“ажил хийхэд бэлэн” гэж Хөдөлмөрийн тухай болон Иргэний хуулийн 359 дүгээр зүйлд заасан хөлсөөр ажиллах болон ажил гүйцэтгэх гэрээ байгуулахаас татгалзахгүй байхыг;

-“ажил идэвхтэй хайж байгаа ” гэж ажилд зуучлах төрийн болон хувийн байгууллагад бүртгүүлж, нэгээс доошгүй удаа ажлын байрны талаар мэдээлэл авсан эсхүл ажлын зар, цахим хуудсаар ажил олгогчид хандах, нийтийн үйлчилгээний газруудын мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зар тавих зэрэг ажил олох оролдлого идэвхтэй хийснийг тус тус ойлгоно.

Ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшин – Ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхтэй хүн амыг хөдөлмөрийн насны хүн амд харьцуулсан хувь.

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин – Ажиллагчдын тоог эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд харьцуулсан хувь.

Ажилгүйдлийн түвшин – Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоог эдийн засгийн идэвхтэй хүн амд харьцуулсан хувь.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн хувь – Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоог эдийн засгийн идэвхтэй хүн амд харьцуулсан хувь.

Хүн ам зүйн ачаалал – Хөдөлмөрийн насны нэг хүн амд ногдох хөдөлмөрийн насанд хүрээгүй, хөдөлмөрийн нас хэтэрсэн хүний тоо

Хөдөлмөр эрхлээгүй хүн ам – Хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай, хөлсний болон хувиараа хөдөлмөр эрхэлж цалин, хөлс, орлого олдоггүй, хүндэтгэх ба бусад (хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхолгүй, хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлгүй боловч ажил хайж байгаа, тодорхой шалтгаангүй г.м) шалтгаангаар ажил идэвхитэй эрж хайхгүй байгаа хүн ам. Гэхдээ эдгээрт бүх шатны сургуульд өдрөөр суралцагчид, хугацаат цэргийн албан хаагчид, хоригдол, хөдөлмөрийн насны чадваргүй хүмүүс ороогүй.

Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй хүн ам – Хөдөлмөрийн насны, албан ёсны эрх бүхий байгууллагын нотолгоогоор хөдөлмөрийн чадвараа 6 сараас дээш хугацаагаар түр болон бүрмөсөн алдсан нь тогтоогдсон хөгжлийн бэрхшээлтэй болон холбогдох хуулийн дагуу тэтгэврийн наснаасаа өмнө тэтгэвэр тогтоолгосон (тэтгэвэр тогтоолгоод ажиллаж байгаа хүн орохгүй) хүмүүс.

Хөдөлмөрийн насны суралцагчид – Хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай их, дээд сургууль, коллеж, тусгай мэргэжлийн анхан болон дунд шатны сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, 6 сараас дээш хугацаагаар мэргэжлийн сургалтанд хамрагдагчид, ЕБС-д суралцаж буй иргэд орно.

Оршил

Хүн амын ажил эрхлэлтийн судалгааны үзүүлэлтүүдийг сум, хорооны нутаг дэвсгэрт 6 сараас дээш хугацаагаар оршин суугаа (Монгол Улсын харьяат, манай улсад удаан хугацаагаар оршин сууж байгаа гадаадын болон цагаач иргэд) суурийн хүн амаар гаргадаг.

Энэхүү судалгаанд аймгийн нийт хүн амын чухам хэдэн хувь нь ажил хөдөлмөр эрхэлж байгаа, ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхитэй хүн ам, ажил эрхэлдэг хүн ам буюу ажиллагчид, ажилгүйчүүд, ажил эрхлээгүй хүн амын тоо хэд байгаа, хүн ам зүйн ачаалал, ажиллах хүчний хөдөлмөр оролцоо, ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин ямар байгааг харуулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн өгөөжийг тооцож, үнэлэлт дүгнэлт өгч байна. Улсын хэмжээгээр ажил эрхлэлтийн үзүүлэлтүүдийг ажил эрхлэлтийн судалгааны үр дүнгээр тооцож байгаа болохоор зарим үзүүлэлтүүдийн зэрэгцүүлэлт урьд жилүүдийнхээс хэлбэлзэлтэй гарсан болно. Аймгийн түвшинд ХАӨМСангийн үзүүлэлтээр авч байгаа болохоор зарим үзүүлэлтүүд аймаг бүсийн түвшинд ялгаатай гарч байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Судалгааны товч агуулга

Энэ судалгааны гол зорилго нь эдийн засгийн идэвхтэй хүн амыг тодорхойлж, түүнээс ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшин, ажил эрхлэлтийн түвшин, ажилгүйдлийн түвшинг тооцож зэрэгцүүлэхэд оршино. Эдгээр үзүүлэлтүүдийг аймгийн түвшин, сумуудаар гаргасан. Мөн судалгаанд эдийн засгийн үйл ажиллганы салбар хөдөлмөрийн чадваргүй болон ажил хөдөлмөр эрхлээгүй хүн ам, насны бүлгээр харууллаа.

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн байдал нь ажиллах хүчний урсгал хөдөлгөөн ихтэй, ажиллагсдын бүтээмж бага, хөдөлмөрийн үнэлэмж доогуур хөдөлмөрийн зах зээлд ажиллах хүчний өрсөлдөх чадвар хангалтгүй, ажилгүйчүүдийн дүнд мэргэжлийн хүмүүсийн хувь хэмжээ их байгаа зэрэг сөрөг асуудлууд байна.

Аливаа улс орны эдийн засгийн хөгжил, иргэдийнх нь аж байдал, амжиргааны ерөнхий түвшин нь хүн амынхаа ажил эрхлэлтийн түвшинтэй зохих ёсоор холбоотой байдаг. Өндөр боловсролтой, ур чадвартай ажиллах хүч бол тухайн улс орны хөгжлийг тодорхойлогч нэгэн гол хүчин зүйл. Тухайн орны ажиллах хүч, ажил эрхлэлтийн байдал нь хүн амын насны бүтцээс шууд хамааралтай байдаг. Жил бүр хөдөлмөрийн насанд шилжиж байгаа хүний тоо, хөдөлмөрийн наснаас гарч байгаа хүний тооны зөрүү нь хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай хүний цэвэр өсөлтийг харуулна. Хөдөлмөрийн насанд шилжих хүний тоо нь тайлант жилээс 15 жилийн өмнөх төрөлтийн түвшин, нялхсын болон хүүхдийн нас баралтын түвшингээс хамаардаг билээ.

Аймгийнхаа суурин хүн амын бүтцийг 2011-2015 оны байдлаар авч үзвэл 16 хүртэлх насны хүүхдийн дүнд эзлэх хувийн жин 2011,2012,2014,2015 онуудад ижил түвшинд, 2013 оныхоос 1.5 пунктээр, өндөр настаны эзлэх хувийн жин 2015 онд өмнөх оноос 0.6 пунктээр тус тус буурсан байна. Хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь нь 2015 онд 0.4 пунктээр нэмэгдсэн байна. (Хүснэгт 1)

Хүснэгт №1

Суурин хүн амын насны бүтэц

	2011	2012	2013	2014	2015					2011	2012	2013	2014	2015
						2015 2011	2015 2012	2015 2013	2015 2014					
Суурин хүн ам - Бүгд	89374	88952	90878	93165	101183	113,2	113,8	111,3	108,6	100,0	100,0	100,0	100,0	100,0
Үүнээс:16 хүртэлх настай	32336	31980	34317	33691	36749	113,6	114,9	107,1	109,1	36,2	36,0	37,8	36,2	36,3
Хөдөлмөрийн насны /16-59 настай/	52604	52505	51982	54650	59791	113,7	113,9	115,0	109,4	58,9	59,0	57,2	58,7	59,1
Хөдөлмөрийн нас хэтэрсэн /60 ба дээш/	4434	4467	4579	4824	4643	104,7	103,9	101,4	96,2	5,0	5,0	5,0	5,2	4,6

Хөдөлмөрийн насны хүн амын тоо 2015 онд 2011 оныхоос 0.2 хувь, 2012 оныхоос 0.1 хувь, 2013 оныхоос 1.9 хувь, 2014 оноос 0.4 хувиар өссөн нь тухайн насныхны орон нутагт тогтвор суурьшилтай амьдарч байгааг харуулж байна. 16-59 насныхан аймгийн хүн амын 59.1 хувийг эзэлж байгаа нь манай аймагт хөдөлмөрийн хангалттай нөөц байгааг харуулж байна.

Хүснэгт 2

Хүн амын ажил эрхлэлт

	2011	2012	2013	2014	2015	өсөлт, бууралт			
						2015 2011	2015 2012	2015 2013	2015 2014
Хөдөлмөрийн насны хүн ам	52604	52505	51982	54650	59791	113.7	113.9	115.0	109.4
Эдийн засгийн идэвхтэй хүн ам	31477	30568	31204	32953	34016	108.1	111.3	109.0	103.2
Ажиллагчид	29877	29526	29855	31426	32892	110.1	111.4	110.2	104.7
Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүд	1600	1042	1349	1527	1124	70.3	107.9	83.3	73.6
Ажил эрхлээгүй хүн ам	12816	8256	8354	8759	13069	102.0	158.3	156.4	149.2
Хөдөлмөрийн насны суралцагчид	5988	5559	4632	4145	5152	86.0	92.7	111.2	124.3
Ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшин (%)	59.8	58.2	60.0	60.3	56.9	95.1	97.7	94.8	94.4
Ажил эрхлэлтийн түвшин (%)	94.9	96.6	95.7	95.4	96.7	101.9	100.1	101.1	101.4
Ажилгүйдлийн түвшин ** (%)	5.1	3.4	4.3	4.6	3.3	64.9	96.8	76.3	71.7

Хөдөлмөрийн насны суралцагчдын тоо 2015 онд 2014 оныхоос 24.3 хувиар илүү байгаа нь орон нутагт суралцагчидийн тоо нэмэгдэж байгааг харуулж байна. Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо 2011 оныхоос 8.1, 2012 оныхоос 11.3, 2013 оныхоос 9.0, 2014 оныхоос 3.2 хувиар өсч, жил дараалан эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо зохих түвшинд нэмэгдэж байгааг харуулж байна. Ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхтэй хүн ам 3.2 хувиар, ажиллагчид 4.7 хувиар, ажил эрхлээгүй хүн амын тоо 49.2 хувиар нэмэгдэж, 2014 оныхоос бүртгэлтэй ажилгүйчүүд 26.4

хувиар, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй ажилгүйчүүдээр тооцсон ажилгүйдлийн түвшин 34.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 3

Хүн ам зүйн ачаалал

	2000	2005	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
0-15 насны хүн ам	39494	35836	33655	34698	32804	32336	31980	32454	33691	36749
Хөдөлмөрийн насны хүн ам	50789	56548	55503	53589	51846	52604	52505	53845	54650	59791
Өндөр настаны тоо	3811	3374	4773	4730	4541	4434	4467	4579	4824	4643
Хүн ам зүйн ачаалал	0.85	0.69	0.69	0.74	0.72	0.70	0.69	0.69	0.70	0.69

Улс орнууд хүн амынхаа хөгжлийн ирээдүйн хандлагыг урьдчилан тодорхойлохдоо хүн ам зүйн ачааллыг харгалзан үздэг. Манай аймагт хүн ам зүйн ачаалал буюу хөдөлмөрийн насны нэг хүнд ногдох тэжээлгэгч хүний тооны харьцаа 2005 онд 0.69 байсан бол таван жилийн дараа буюу 2010 онд 0.72 болж 0.03 пунктээр нэмэгдсэн байна. 2015 оны хүн ам зүйн ачаалал өмнөх оныхоос 0.01 пунктээр буурсан байна.

Хүснэгт 4

Ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшин /сумаар /

	2011	2012	2013	2014	2015	<u>2015</u> 2011	<u>2015</u> 2012	<u>2015</u> 2013	<u>2015</u> 2014
Алтай	84.5	82.1	83.1	78.5	74.4	88.1	90.7	89.6	94.8
Алтанцөгц	79.3	62.6	67.6	67.8	65.2	82.3	104.3	96.5	96.2
Баяннуур	76.5	57.1	47.3	52.5	50.1	65.5	87.7	105.8	95.3
Бугат	77.0	66.6	62.1	58.0	57.7	75.0	86.7	93.0	99.6
Булган	69.8	62.3	70.0	61.0	59.5	85.2	95.5	85.0	97.5
Буянт	70.7	68.9	75.8	75.3	69.3	98.0	100.7	91.5	92.1
Дэлүүн	89.3	56.4	63.5	61.0	57.9	64.9	102.6	91.3	95.0
Ногооннуур	89.5	80.8	76.6	83.3	79.1	88.3	97.8	103.2	95.0
Сагсай	90.7	74.9	67.6	71.0	68.6	75.7	91.7	101.4	96.7
Толбо	80.9	75.3	76.8	74.6	69.8	86.2	92.7	90.9	93.6
Улаанхус	77.8	73.4	80.9	72.6	69.7	89.6	94.9	86.1	96.0
Цэнгэл	83.6	82.8	85.7	82.4	78.8	94.3	95.2	92.0	95.7
Өлгий	35.9	36.7	38.3	41.1	39.6	110.2	107.8	103.2	96.2
Цагааннуур	48.2	44.5	60.4	43.6	39.5	82.0	88.8	65.5	90.8
Дүн	64.4	58.2	60.0	60.3	56.9	88.3	97.7	94.8	94.4

Хөдөлмөрийн зах зээлийн хөгжил, хүн амын эдийн засгийн идэвхтэй байдлыг харуулдаг гол үзүүлэлт болох ажиллах хүчний оролцооны түвшин 56.9 болж 2014 оныхоос 3.4 пунктээр буурсан байна. Ажиллах хүчний оролцооны түвшинг сумаар авч үзвэл Ногооннуур, Цэнгэл, Алтай, Толбо, Улаанхус, Буянт, Алтанцөгц сумдад хамгийн өндөр буюу 79.1-65.2 хувьтай, Цагааннуур, Өлгий, Баяннуур, Дэлүүн,

Бугат,Булган сумдад хамгийн бага буюу 39.5-59.5 хувьтай байна. Ажиллах хүчний оролцооны түвшинг сүүлийн жилүүдээр зэрэгцүүлэхэд өмнөх онууд буюу 2011-2014 оныхоос 7.5 -1.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 5


Эдийн засгийн идэвхгүй хүн ам /хүйс, насны бүлэг, байршлаар /
/ Ажиллах хүчний судалгааны үр дүнгээр /

	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Хот		Бүгд	Хөдөө	
					Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	19290	8087	11203	7229	3197	4032	12061	4890	7171
15 - 19	6462	2930	3532	2412	1240	1172	4051	1690	2361
20 - 24	1480	482	998	514	183	332	966	299	666
25 - 29	570	185	386	278	45	233	292	140	152
30 - 34	390	46	344	94		94	296	46	250
35 - 39	373	91	282	241	48	193	132	42	90
40 - 44	437	200	237	237	93	144	200	107	93
45 - 49	284	96	188	188	46	143	96	50	45
50 - 54	1136	372	764	887	372	515	249		249
55 - 59	2133	556	1577	840	417	423	1293	139	1154
60 - 64	2092	1057	1034	619	434	185	1472	624	849
65 - 69	1411	858	552	228	91	137	1183	767	415
70 +	2521	1213	1308	690	228	462	1832	985	847

Ажиллах хүчний судалгааны үр дүнгээр хөдөлмөр эрхлээгүй хүний тоо 19290 болж, 2014 оноос 10.0 хувиар буюу 1738 нэмэгдсэн байна.Хөдөлмөр эрхлээгүй хүний 58.1 хувийг эмэгтэйчүүд эзлэж байгаагийн 36.0 хувь нь хот суурин газарт, 64.0 хувь нь хөдөө амьдардаг эмэгтэйчүүд байна.15-19 насныхан эдийн засгийн идэвхгүй хүн амын 33.5 хувийг эзлэж байна.Улсын хэмжээний эдийн засгийн идэвхгүй хүн амын 2.5 хувийг, баруун бүсийн эдийн засгийн идэвхгүй хүн амын 28.7 хувийг манай аймаг эзлэж байна.Судалгааны үр дүнгээр хөдөө амьдардаг иргэд эдийн засгийн идэвхгүй хүн амын дийлэнхийг буюу 64.5 хувийг нь эзлэж байгаа нь хөдөлмөрийн зах зээл хөдөө хомс байгааг харуулж байна.

Зураг 1

Эдийн засгийн идэвхгүй хүн амын насны бүтэц /хувиар/



Хүснэгт 6


Эдийн засгийн идэвхгүй хүн ам /хүйс, шалтгаан, байршлаар/

/ Ажиллах хүчний судалгааны үр дүнгээр /

	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Хот		Бүгд	Хөдөө	
					Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй
<i>Бүгд</i>	19290	8087	11203	7229	3197	4032	12061	4890	7171
Гэрийн ажилтай	1285	536	749	317	137	180	968	399	569
Суралцдаг	5540	2331	3209	2228	1094	1134	3312	1238	2074
Тэтгэвэрт	8415	3411	5004	2567	984	1582	5849	2426	3422
Хөгжлийн бэрхшээлтэй	2062	1088	975	837	505	332	1225	582	643
Ажил хийхийг хүсээгүй	196	49	147	148	49	99	49	0	49
Хүүхэд асарсан	823	91	732	466	45	421	357	46	311
Өвчтэй байсан	541	341	200	383	239	144	157	102	56
Өвчтөн, өндөр настан	235	95	140	189	49	140	46	46	
Сурахаар явах гэж байгаа	50	50					50	50	
Бусад	142	94	48	94	94		48		48

Зураг 2

Эдийн засгийн идэвхгүй хүн амын бүтэц /шалтгаанаар/



2014 оны судалгаагаар эдийн засгийн идэвхгүй хүн амын 29.0 хувь суралцагчид, 43.0 хувь нь тэтгэвэртэн, 11.0 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй, 7.0 хувь нь гэрийн ажилтай иргэд байна. Хот суурин газрын хөдөлмөр эрхлээгүй хүн амын 55.8 хувийг, хөдөөгийн хөдөлмөр эрхлээгүй хүн амын 59.5 хувийг эмэгтэйчүүд эзлэж байна.

Хүснэгт 7

**Баруун бүсийн аймгуудын хөдөлмөр эрхлэлтийн зарим
үзүүлэлтүүдийн зэрэгцүүлэлт / судалгааны үр дүнгээр /**

Баруун бүсийн аймгууд	Ажил эрхлэлтийн түвшин					Хөдөлмөр эрхлээгүй хүний тоо				
	2011	2012	2013	2014	2015	2011	2012	2013	2014	2015
Баян-Өлгий	92.9	87.6	54.3	56.2	63.4	3160	6389	10531	10425	5869
Увс	89.1	91.6	69.9	65.7	70.1	2952	3177	3777	5064	3279
Ховд	81.8	92.0	60.6	61.1	62.8	6693	2994	2102	3938	3107
Говь-Алтай	89.7	86.3	66.6	65.3	70.2	4225	4183	2895	2717	2403
Завхан	91.3	93.6	68.0	77.3	68.2	3279	2547	2077	1501	2218
Улсын дундаж	92.3	91.8	57.0	57.2	56.9	87030	94705	94732	95856	92672

Судалгааны үр дүнгээр тооцож гаргасан бүсийн болон улсын дүнгийн тоо мэдээлэлүүд нь аймгийн сумаар гаргасан тооноос ялгаатай байгаа. Судалгааны үр дүнгээр тооцсон ажил эрхлэлтийн түвшингээр баруун бүсийн аймгуудын дотороос хамгийн бага хувийг Ховд аймаг, хамгийн өндөр хувийг Завхан аймаг эзлэж байна. Хөдөлмөр эрхлээгүй хүний тоогоор баруун бүсийн аймгуудаас хамгийн өндөрт Баян-Өлгий аймаг, хамгийн багад Завхан аймаг орж байна.

Хүснэгт 8


**Ажилгүйдлийн үзүүлэлтүүд
/ Ажиллах хүчний судалгааны үр дүнгээр /**

Аймаг	Ажилгүйдлийн түвшин					Ажилгүйчүүдийн тоо				
	2011	2012	2013	2014	2015	2011	2012	2013	2014	2015
Баян-Өлгий	7.0	12.4	23.5	22.5	11.9	1038	6389	10531	10425	5869
Говь-Алтай	10.8	13.7	10.8	10.2	8.8	787	4183	2895	2717	2403
Завхан	18.2	6.4	5.6	4.0	6.9	1457	2547	2077	1501	2218
Увс	10.4	8.4	10.1	14.8	8.5	781	3177	3777	5064	3279
Ховд	8.6	8.0	6.3	11.7	8.6	2132	2994	2102	3938	3107
Баруун бүс	10.8	9.8	11.9	13.3	9.2	6195	19290	21382	23645	16876
Улсад	7.7	8.2	7.9	7.9	7.5	57171	94705	94732	95856	92672

2015 оны судалгааны үр дүнгээр хамгийн их ажилгүйчүүдтэй аймаг Баян-Өлгий, хамгийн бага ажилгүйчүүдтэй аймаг Завхан аймаг байна. Судалгааны үр дүнгээр тооцсон ажилгүйдлийн түвшингээр баруун бүсийн аймагуудаас хамгийн өндөр хувийг Баян-Өлгий аймаг эзлэж байна.

Баруун бүсийн ажилгүйчүүдийн 34.8 хувийг, улсын хэмжээний нийт ажилгүйчүүдийн 6.3 хувийг эзэлж байна.

Зураг 3

Ажилгүй иргэдийн бүтэц /боловсролын түвшингээр/

2015 оны ажиллах хүчний судалгааны үр дүнгээр тооцсон ажилгүйдлийн тоо 5869 байгаагийн 45.3 хувийг дипломын дээд болон бакалаврын боловсролтой иргэд, 0.9 хувийг тусгай мэргэжлийн дунд, 10.7 хувийг бүрэн дунд боловсролтой иргэд, 22.7 хувийг техникийн мэргэжлийн боловсролтой иргэд, 7.3 хувийг суурь боловсрол эзэмшигчид, 9.8 хувийг бага боловсролтой иргэд, 3.3 хувийг боловсролгүй иргэд эзлэж байна. Мэргэжлийн давхардал их буюу ажлын байр хомс илүүдэлтэй мэргэжил эзэмшигчидийн тоо их байгаа нь дээд боловсролтой иргэдийн эзлэх хувийн жин өндөр байгаагаас харагдаж байна. (Зураг 3)

Хүснэгт 9

Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй хүний тоо

Он	Хөдөлмөрийн чадваргүй - Бүгд	2015 онтой харьцуулсан хувь
2011 он	3267	139.3
2012 он	3393	134.1
2013 он	3844	118.4
2014 он	3485	130.6
2015 он	4551	

Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй хүний тоо 2015 онд 4551 болж өмнөх онуудаас 39.3-30.6 хувиар нэмэгдсэн байна.

Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй хүн амд хөдөлмөрийн насны, зохих журмын дагуу хөдөлмөрийн чадвар алдалтыг магадлан тогтоох комиссын

нотолгоогоор хөдөлмөрийн чадвараа 6 ба түүнээс дээш түр болон бүрэн алдсан нь тогтоогдсон хөгжлийн бэрхшээлтэй болон холбогдох хуулийн дагуу тэтгэврийн наснаасаа өмнө тэтгэвэр тогтоолгосон (тэтгэвэр тогтоолгоод ажиллаж байгаа хүн орохгүй) хүмүүсийг хамруулсан.


Хүснэгт 10

Хөдөлмөрийн насны суралцагчдын бүтэц

	2011	2012	2013	2014	2015	2015 2014	Бүтэц				
							2011	2012	2013	2014	2015
Эрэгтэй	2714	2532	2200	1931	2382	123.4	45.3	45.5	47.5	46.6	46.2
Эмэгтэй	3274	3027	2432	2214	2770	125.1	54.7	54.5	52.5	53.4	53.8
Бүгд	5988	5559	4632	4145	5152	124.3	100.0	100.0	100.0	100.0	100.0

Зураг 4

Хөдөлмөрийн насны суралцагчдын бүтэц хүйсээр / хувиар /



Хөдөлмөрийн насны суралцагчид 2011 онд 5988 байсан бол 2012 онд 5559, 2013 онд 4632, 2014 онд 4145, 2015 онд 5152 болж жил дараалан буурсаар байна. Өмнөх онтой харьцуулахад 24.3 хувь буюу 1007 хүнээр нэмэгдсэн байна. Нийт суралцагчдын 53.8 хувийг эмэгтэй суралцагчид эзэлж өмнөх оныхоос 0.4 пунктээр нэмэгдсэн байна.


Суурин болон хөдөлмөрийн насны хүн амын тоо /сумаар/

	Суурин хүн ам			Хөдөлмөрийн насны хүн ам	Суурин хүн амд	
	Бүгд	Үүнээс эмэгтэй	Хувь		Хөдөлмөрийн насны эзлэх %	Хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувийн жин
					Бүгд	
Алтай	4209	2026	48.1	2491	59	4.2
Алтанцөгц	2858	1426	49.9	1691	59	2.8
Баяннуур	5065	2889	57.0	2852	56	4.8
Бугат	3682	1826	49.6	2127	58	3.6
Булган	5423	2683	49.5	3189	59	5.3
Буянт	2736	1360	49.7	1672	61	2.8
Дэлүүн	7296	3667	50.3	4228	58	7.1
Ногооннуур	6369	3159	49.6	3635	57	6.1
Сагсай	5111	2560	50.1	2862	56	4.8
Толбо	4108	2049	49.9	2382	58	4.0
Улаанхус	8453	4193	49.6	4760	56	8.0
Цэнгэл	9194	4592	49.9	5197	57	8.7
Өлгий	35124	17492	49.8	21688	62	36.3
Цагааннуур	1555	783	50.4	1017	65	1.7
Дүн	101183	50705	50.1	59791	59	100.0

Хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувийн жин өндөр Өлгий, Цэнгэл, Улаанхус, Дэлүүн, Ногооннуур, Булган сумууд байна. Хөдөлмөрийн насны хүн ам 2014 оноос 9.4 хувиар буюу 5141 хүнээр нэмэгдсэн байна.

Зураг 5

Хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь



Хүснэгт 12

**Хүн амын ажил эрхлэлтийн судалгаагаар хамгийн их бага
үзүүлэлттэй сумд**

	Хэмжих нэгж	Аймгийн дундаж	2015 он			
			Хамгийн		Их	Бага
			Их	Бага		
Хөдөлмөрийн насны 1000 хүн амд ногдох ажиллагчдын тоо	Хүн	550	Ногооннуур	787	Өлгий	351
			Цэнгэл	786	Цагааннуур	395
			Алтай	741	Баяннуур	498
Хөдөлмөрийн насны 1000 хүн амд ногдох тэжээвэр хүний тоо	Хүн	692	Сагсай	786	Цагааннуур	529
			Улаанхус	776	Өлгий	620
			Баяннуур	776	Буянт	636
Хөдөлмөрийн насны 1000 хүн амд ногдох тэжээвэр хүнээс - хүүхдийн тоо	Хүн	615	Сагсай	698	Цагааннуур	519
			Цэнгэл	696	Өлгий	547
			Улаанхус	693	Буянт	556
Хөдөлмөрийн насны 1000 хүн амд ногдох тэжээвэр хүнээс-өндөр настны тоо	Хүн	78	Алтанцөгц	99	Өлгий	72
			Толбо	93	Цэнгэл	73
			Сагсай	88	Ногооннуур	76
Хөдөлмөрийн насны 1000 хүн амд ногдох ажилгүйчүүдийн тоо	Хүн	19	Өлгий	45	Цэнгэл	2
			Буянт	9	Баяннуур	2
			Алтанцөгц	7	Толбо	2
Хөдөлмөрийн насны 1000 хүн амд ногдох ажил эрхлээгүй хүн	Хүн	219	Өлгий	353	Цэнгэл	66
			Баяннуур	324	Булган	68
			Цагааннуур	183	Алтай	81
Хөдөлмөрийн насны 1000 хүн амд ногдох ажил хөдөлмөрийн чадваргүй хүн	Хүн	76	Толбо	186	Цагааннуур	5
			Булган	184	Алтай	46
			Баяннуур	104	Өлгий	47
Хөдөлмөрийн насны хүн амын тоогоор	Хүн	59791	Өлгий	21688	Цагааннуур	1017
			Цэнгэл	5197	Буянт	1672
			Улаанхус	4760	Алтанцөгц	1691
Ажиллагчдын тоогоор	Хүн	32892	Өлгий	7602	Цагааннуур	402
			Цэнгэл	4085	Алтанцөгц	1092
			Улаанхус	3298	Буянт	1144
Хөдөлмөрийн насны хүнээс хөдөлмөр эрхлээгүй	Хүн	13069	Өлгий	7663	Цагааннуур	186
			Улаанхус	936	Алтай	203
			Баяннуур	923	Булган	216
Ажиллах хүчний тоогоор	Хүн	34016	Өлгий	8581	Цагааннуур	402
			Цэнгэл	4097	Алтанцөгц	1103
			Улаанхус	3318	Буянт	1159

Хүснэгт 13


**Ажиллагчид, бүртгэлтэй ажилгүй иргэд /хүйс, бүсээр/
/АХС-ны үр дүнгээр/**

Аймаг	Ажиллагчид /мян.хүн/					Бүртгэлтэй ажилгүй иргэд									
	2011	2012	2013	2014	2015	2011		2012		2013		2014		2015	
						Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
Бүгд	1037.7	1056.4	1103.6	1110.7	1151.2	57171	26043	35776	18766	42772	23470	36970	20459	32788	17720
Баруун бүс	167.8	177.6	158.4	154.6	166.7	6195	3042	5511	2898	6463	3495	5636	3059	4597	2484
Баян-Өлгий	42.0	45.1	34.3	36.0	43.6	1038	579	513	198	1349	675	1445	768	1058	525
Говь-Алтай	24.4	26.3	23.9	23.9	25.1	787	361	840	540	1214	669	912	509	644	336
Завхан	30.1	37.3	35.3	35.8	29.9	1457	631	1436	786	935	513	804	450	450	263
Увс	36.6	34.7	33.6	29.2	35.2	781	348	1002	577	1350	774	1138	617	1163	569
Ховд	34.7	34.2	31.3	29.7	32.0	2132	1123	1720	797	1615	864	1337	715	1282	791
Баруун бүсд эзлэх хувь	25.0	25.4	21.7	23.3	26.2	16.8	19.0	9.3	6.8	20.9	19.3	25.6	25.1	23.0	21.1
Улсын дүнд эзлэх хувь	4.0	4.3	3.1	3.2	3.8	1.8	2.2	1.4	1.1	3.2	2.9	3.9	3.8	3.2	3.0

Ажиллагчидын тоо өмнөх оныхоос 21.1 хувиар нэмэгдэж, баруун бүсийн аймгуудаас бүс болон улсын дүнд эзлэх хувийн жин хамгийн өндөр аймгийн тоонд орж байна. Мөн бүртгэлтэй ажилгүйчүүдээр тооцсон хувийн жингээр бүс дотор хамгийн өндөр /23.0/ хувийн жинтэй аймаг байна.

Зураг 6

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн эзлэх хувь



Хүснэгт 14

Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшин /сумаар/

Сумын нэр	2011	2012	2013	2014	2015	өсөлт, бууралт			
						<u>2015</u> 2011	<u>2015</u> 2012	<u>2015</u> 2013	<u>2015</u> 2014
Алтай	97.2	97.4	99.2	98.1	99.6	102.5	102.2	100.4	101.5
Алтанцөгц	94.0	95.8	98.5	96.5	99.0	105.3	103.4	100.5	102.6
Баяннуур	94.5	96.2	98.5	96.9	99.5	105.3	103.5	101.0	102.7
Бугат	97.4	98.2	98.1	96.5	99.6	102.3	101.4	101.5	103.2
Булган	96.3	97.7	95.1	94.7	99.4	103.2	101.8	104.6	105.0
Буянт	97.5	98.0	98.9	95.2	98.7	101.3	100.7	99.8	103.7
Дэлүүн	96.0	96.9	99.2	96.2	99.3	103.4	102.5	100.1	103.2
Ногооннуур	97.3	97.9	98.2	98.3	99.5	102.2	101.6	101.4	101.2
Сагсай	95.7	97.3	98.7	97.9	99.0	103.5	101.8	100.4	101.1
Толбо	96.1	97.2	97.1	95.2	99.7	103.7	102.6	102.6	104.7
Улаанхус	98.1	99.0	99.3	98.6	99.4	101.3	100.4	100.1	100.8
Цэнгэл	97.9	98.3	98.0	98.3	99.7	101.9	101.4	101.8	101.4
Өлгий	96.7	93.1	87.5	89.0	88.6	91.6	95.1	101.2	99.5
Цагааннуур	89.6	92.3	90.0	100.0	100.0	111.6	108.4	111.1	100.0
Дүн	96.6	96.6	95.7	95.4	96.7	100.1	100.1	101.1	101.4


2015 оны байдлаар ажил эрхлэлтийн түвшин 96.7 болж 2014 оныхоос 1.3 пунктээр өссөн байна. Хөдөлмөрийн насны хүн амын 50.0 хувь нь албан ба албан бус хөдөлмөр эрхэлж, 21.8 хувь нь ажил хөдөлмөр эрхэлдэггүй, 3.7 хувь нь бүртгэлтэй ажилгүйчүүд, 8.6 хувь нь суралцагчид, 7.6 хувь нь хөдөлмөрийн чадваргүй хүмүүс байна. Аймгийн нийт ажиллагсадын 60.1 хувийг хөдөө аж ахуйн салбарт, 17.5 хувь төсөвт байгууллагад ажилладаг байна.

Ажиллагсад эдийн засгийн салбарын ангилалаар

Эдийн засгийн салбарууд	2011	2012	2013	2014	2015	<u>2015</u> <u>2014</u>
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	18895	18480	17866	19189	19761	103.0
Загас агнуур	11	11				
Уул уурхай	168	249	501	535	382	71.4
Боловсруулах үйлдвэр	567	546	554	664	1105	166.4
Цахилгаан, дулааны эрчим хүч, ус түгээх	302	317	323	335	346	103.3
Барилга	409	390	523	619	675	109.0
Бөөний ба жижиглэн худалдаа	2311	2169	2138	2450	2753	112.4
Зочид буудал, зоогийн газар	220	220	240	339	341	100.6
Тээвэр агуулах, холбоо	542	602	697	548	574	104.7
Санхүүгийн байгууллага	271	286	294	310	313	101.0
Үл хөтлөх хөрөнгө бизнес, түрээс	101	120	164	103	108	104.9
Төрийн захиргаа батлан хамгаалах	1462	1338	1455	1437	1403	97.6
Боловсрол	3318	3417	3692	3506	3686	105.1
Эрүүл мэнд	1045	1075	1115	1180	1233	104.5
НАА, нийгэм хүн амын үйлчилгээ	202	255	244	173	170	98.3
Олон улсын байгууллагын болон хөлсний ажилчинтай өрхийн аж ахуй	53	51	49	38	42	110.5
Дүн	29877	29526	29855	31426	32892	104.7

Ажиллагчдын 60.1 хувийг хөдөө аж ахуйн салбарт ажиллагсад, 1.2 хувийг уул уурхайн салбарт ажиллагсад, 1.1 хувийг цахилгаан дулааны эрчим хүч, ус түгээх үйл ажиллагааны салбарт ажиллагсад, 3.4 хувийг боловсруулах үйлдвэрийн салбарт ажиллагсад, 2.0 хувийг барилгын салбарт ажиллагсад, 8.4 хувийг худалдааны салбарт ажиллагсад, 11.2 хувийг боловсролын салбарт ажиллагсад, 4.3 хувийг төр захиргаа, батлан хамгаалах салбарт ажиллагсад, 3.7 хувийг эрүүл мэндийн салбарт ажиллагсад, 1.0 хувийг санхүүгийн байгууллагын салбарт ажиллагсад, зочид буудал зоогийн газрын салбарт ажиллагсад 1.0 хувийг, 0.3 хувийг үл хөдлөх хөрөнгө түрээс, бизнесийн салбарт ажиллагсад, 0.6 хувийг шашны болон олон улсын байгууллагын салбарт ажиллагсад, 1.7 хувийг тээвэр холбооны салбарт ажиллагсад тус тус эзлэж байна.

Зураг 7



Янз бүрийн шалтганаар 13069 хүн ажил хөдөлмөр эрхлээгүй байгаа ба үүнээс хүүхэд, өндөр настан, өвчтөн асардаг, өвчтэй, гэр бүлийн хүний ажлын онцлог, гэрийн ажилтай зэрэг шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй хүмүүсийг хасвал 5722 гаруй хүн хүндэтгэх шалтгаангүй тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй, ажил хөдөлмөр эрхлэх хүсэлтэй хүмүүс байна. Хөдөлмөр эрхэлж байгаа нийт хүний 39.7 хувьтай тэнцэх хүн 2015 онд хөдөлмөр эрхлээгүй байна.

Хүснэгт 16

Ажил эрхлээгүй хүний тоо /сумаар/

Сумын нэр	2011	2012	2013	2014	2015	өсөлт, бууралт			
						2015 2011	2015 2012	2015 2013	2015 2014
Алтай	199	182	196	149	203	102.0	111.5	103.6	136.2
Алтанцөгц	304	170	184	204	287	94.4	168.8	156.0	140.7
Баяннуур	786	580	638	821	923	117.4	159.1	144.7	112.4
Бугат	229	45	113	213	275	120.1	6.1 дах	2.4 дах	129.1
Булган	463	109	86	173	216	46.7	2.0 дах	2.5 дах	124.9
Буянт	156	166	188	192	254	162.8	153.0	135.1	132.3
Дэлүүн	578	535	604	563	596	103.1	111.4	98.7	105.9
Ногооннуур	134	178	510	601	648	4.8 дах	3.6 дах	127.1	107.8
Сагсай	423	217	273	214	263	62.2	121.2	96.3	122.9
Толбо	72	73	270	210	278	3.8 дах	3.8 дах	103.0	132.4
Улаанхус	630	69	19	712	936	148.6	1.4 дах	49.3 дах	131.5
Цэнгэл	286	218	196	283	341	119.2	156.4	174.0	120.5
Өлгий	7961	5554	4917	4270	7663	96.3	138.0	155.8	1.8 дах
Цагааннуур	419	160	160	154	186	44.4	116.3	116.3	120.8
Дүн	12640	8256	8354	8759	13069	103.4	158.3	156.4	149.2

Сумуудын хөдөлмөр эрхлээгүй хүний тоог өмнөх онтой харьцуулахад 5.9- 79.5 хувиар нэмэгдсэн байна.Хөдөлмөр эрхлээгүй хүний 58.6 хувь нь аймгийн төвд амьдарч байна.Хөдөлмөр эрхлээгүй хүмүүсийн дунд их, бага хэмжээгээр хөдөлмөр эрхэлж орлого олдог хүмүүс байхыг үгүйсгэх аргагүй.(улирлын чанартай хөлсний ажил хийх, гудамж талбайд наймаа хийх г.м)

Хүснэгт 17

Ажилгүйдлийн түвшин / сумаар /

Сумын нэр	2011	2012	2013	2014	2015	өсөлт, бууралт			
						<u>2015</u> 2011	<u>2015</u> 2012	<u>2015</u> 2013	<u>2015</u> 2014
Алтай	2.9	2.6	0.8	1.9	0.4	14.9	16.6	54.2	22.8
Алтанцөгц	6.4	4.2	1.5	3.5	1.0	15.6	23.7	65.0	28.2
Баяннуур	5.8	3.8	1.5	3.1	0.5	8.4	12.9	33.7	15.7
Бугат	2.7	1.8	1.9	3.5	0.4	15.0	22.6	21.8	11.7
Булган	3.8	2.3	4.9	5.3	0.6	15.1	25.2	11.8	10.9
Буянт	2.6	2.0	1.1	4.8	1.3	50.1	64.7	117.1	26.8
Дэлүүн	4.2	3.1	0.8	3.8	0.7	16.7	22.4	92.4	18.4
Ногооннуур	2.7	2.1	1.8	1.7	0.5	19.1	24.9	28.2	30.7
Сагсай	4.5	2.7	1.3	2.1	1.0	21.3	35.8	73.4	46.3
Толбо	4.0	2.8	2.9	4.8	0.3	7.4	10.7	10.5	6.3
Улаанхус	2.0	1.0	0.7	1.4	0.6	30.7	60.3	87.8	44.6
Цэнгэл	3.0	1.7	2.0	1.7	0.3	9.8	17.2	14.5	17.7
Өлгий	11.9	6.9	12.5	11.0	11.4	95.6	1.6 дах	91.5	103.8
Цагааннуур	11.6	7.7	10.0						
Дүн	5.4	3.4	4.3	4.6	3.3	61.6	97.1	76.3	71.7
Улсын дундаж	10.8	8.2	7.9	7.9	7.5	69.4	91.5	94.9	94.9
Баруун бүс	7.7	9.8	11.9	13.3	9.2	119.5	93.9	77.3	69.2

Хөдөлмөрийн хэлтэс болон сумдын засаг даргын тамгын газарт бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1124 байгаа нь урьд оныхоос 26.4 хувиар буурсан байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдээр тооцсон ажилгүйдлийн түвшин нь өмнөх оныхоос 1.3 пунктээр буурсан байна.


Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэлийн сан бий болгох үүднээс бүртгэл, судалгааг сайжруулах зорилгоор дэд шатны байгууллагуудаас батлагдсан маягтын дагуу хөдөлмөрийн зах зээлийн анхан шатны бүртгэлийг шинэчилэх ажил хийгдсэнээр ажилгүй иргэдийг бүртгэх ажлыг эрчимжүүлэн төсөл хөтөлбөрт хамруулан сургах, ажилд зуучлан оруулах, бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах ажлууд хийгдэж байна.

Ажилгүйчүүдийн тоо

Сумын нэр	Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох ажилгүйчүүд									
	2011	2012	2013	2014	2015	2011	2012	2013	2014	2015
Алтай	59	35	14	35	8	27	16	7	15	3
Алтанцөгц	62	34	15	39	11	40	22	10	24	7
Баяннуур	87	24	18	45	7	34	9	7	16	2
Бугат	34	5	22	41	5	19	3	12	20	2
Булган	69	38	94	102	11	22	13	34	32	3
Буянт	25	15	12	57	15	18	10	8	37	9
Дэлүүн	91	47	18	94	17	26	12	5	23	4
Ногооннуур	70	46	44	48	15	20	15	14	14	4
Сагсай	83	39	23	41	19	32	15	9	15	7
Толбо	65	42	46	81	5	32	20	22	36	2
Улаанхус	55	22	23	42	20	14	5	6	9	4
Цэнгэл	82	49	79	69	12	24	11	17	14	2
Өлгий	214	616	890	833	979	41	33	48	46	45
Цагааннуур	42	30	51			52	34	60		
Дүн	1038	1042	1349	1527	1124	31	20	26	28	19

Зураг 8


Бүртгэлтэй ажилгүйчүүдийн боловсролын түвшин / 2015 оны байдлаар /



2015 оны жилийн эцсийн байдлаар бүртгэлтэй ажилгүйчүүдийн 32.6 хувь нь дээд, 42.2 хувь нь бүрэн дунд, 7.5 хувь нь бүрэн бус дунд, 10.4 хувь нь тусгай мэргэжлийн, 4.9 хувь нь техник мэргэжлийн, 2.2 хувь нь бага болосролтой, 0.2 хувь нь боловсролгүй иргэд байна. (Зураг 9)

Зураг 9

Ажилгүйчүүдийн тоо / насны бүлгээр /



Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүтэцээр авч үзвэл 41.5 хувийг 25-34 насныхан, 21.5 хувийг 35-44 насныхан, 18.9 хувийг 15-24 насныхан, 18.1 хувийг 45-60 насныхан эзлэж байна.


Хүснэгт 19

Шинээр бий болсон ажлын байр / салбараар /

Салбараар	2011	2012	2013	2014	2015
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	1049	551	79	191	203
Уул уурхай олборлох	72			264	9
Боловсруулах үйлдвэр	259	307	200	382	470
Цахилгаан эрчим хүч, дулаан, усан хангамж			11	11	7
Барилгын салбарт	575	415	533	257	88
Бөөний ба жижиглэнгийн худалдаа		48	69	41	362
Зочид буудал зоогийн газар		26	101	24	46
Тээвэр, тээш хадгалалт, холбоо	47	15	72	17	19
Банк санхүүгийн байгууллага	42	21	59	15	3
Төр захиргаа батлан хамгаалах	98	16	50	44	27
Боловсрол	155	71	55	104	180
Эрүүл мэнд	36	8	27	33	43
Нийтийн аж ахуйн, нийгмийн үйлчилгээ	134	34	161	153	26
Төсөл хөтөлбөр, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа			507	64	37
Энгийн ажил мэргэжил		16	132		31
Бүгд	2467	1528	2056	1600	1551

Зураг 10

Шинэ ажлын байр 2015 он



2015 онд 1631 хүний ажлын байрны захиалга ирсэнээс 1212 хүн зуучлагдаж ажилд орсон байна. 1551 хүн шинэ ажлын байртай болсоны 13.1 хувь нь ХАА, 30.3 хувь нь боловсруулах үйлдвэрт, 5.7 хувь нь барилгын салбарт, 23.3 хувь нь худалдаа үйлчилгээний салбарт, 1.7 хувь төр захиргааны байгууллагуудад, 11.6 хувь нь боловсролын салбарт, 2.8 хувь нь эрүүл мэндийн салбарт, 3.1 хувь нь зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээний салбарт, 1.2 хувь нь тээвэр, тээш хадгалалт, холбооны салбарт, 2.4 хувь нь төсөл хөтөлбөр, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт, 2.0 энгийн ажил мэргэжилтийн салбарт, 1.7 хувь нь нийтийн аж ахуйн, нийгмийн үйлчилгээний салбарт, 0.6 хувь нь уул уурхай, олборлолтын салбарт, 0.5 хувь нь цахилгаан эрчим хүч, дулаан, усан хангамжын салбарт бий болсон байна.

Шинэ ажлын байр 2015 онд 1551 болж өнгөрсөн оноос 3.1 хувиар буурсан байна.

Зураг 11

Ажлын байрны захиалга, зуучлал




2015 онд 1212 бүртгэлтэй ажилгүйчүүд ажилд зуучлагдан орсон байна.

Хөдөлмөрийн хэлтэс болон сумдын Засаг даргын тамгын газарт бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1124 байгаа нь 2014 оныхоос 26.4 хувиар буурч, 2015 онд 1551 шинэ ажлын байр бий болсон байна.

Засгийн газрын зүгээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжихдээ хууль эрх зүйн болон бусад таатай орчинг бүрдүүлэхэд анхаарч, Улсын Их Хурлаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг баталж, 2011 оны 6 дугаар сарын 1-нээс эхлэн мөрдөж байна. Энэ хуулийн гол агуулга нь сургалт, зөвлөлгөө, мэдээллээр хангах, мэргэжлийн сургалт, давтан сургалт явуулах, хувийн аж ахуй эрхэлт, хоршоодыг дэмжих, ажил олгогч нарыг дэмжих, нийтийг хамарсан түр хугацааны хөдөлмөр эрхлэх ажлыг зохион байгуулах зэрэгт чиглэж байна. Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын хөрөнгө оруулалт, тусламж, хандив, бусад эх үүсвэрүүдээс бүрдэх Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санг дээрх хуулийн дагуу байгуулан зарцуулж байна.

Зураг 12

Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн зарцуулалт / оноор /



2015 онд 15 төрлийн арга хэмжээ, төсөл, хөтөлбөр хэрэгжиж хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас зарцуулсан хөрөнгийн хэмжээ өмнөх оныхоос 42.4 хувиар өссөн байна.

2015 онд хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох ажлын байр хадгалах хөтөлбөрүүд шинээр хэрэгжигдсэнээр 561 иргэн хамрагдаж, 269866,1 мянган төгрөг зарцуулагдсан байна.


Хүснэгт 20

Аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулсан хөрөнгө

Д/Д	Сангийн зарлагын зориулалт	2011	2012	2013	2014	2015
1	Иргэдэд ажил мэргэжлээ сонгох, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт	85233.1	7738.7	8653	9677.5	13500.0
2	Ажилд зуучлах	8932.5	2182.4	2223.8	5755.0	6000.0
3	Нийтийг хамарсан хөтөлбөр	206485.6	131359.7	153027.0	114199.8	80721.2
4	Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ	213356.7	24757.8	32672.6	42757.2	68208.0
5	Зээлийн хүүгийн нөхөн төлбөр	11357.0	1792.5	2608.8	1735.0	1899.0
6	Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр			8343.2	650.0	480.0
7	Хөдөлмөр эрхлэлтийн сургалт			80747.5	50020.0	
8	Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр			248066.6	125000.0	240840.0
9	Ажил олоход хүндрэлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ			1302.0	20000.0	
10	Аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөр				31515.0	
11	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих				29796.4	42200.0
12	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр				73000.0	93454.0
13	Бусад хөтөлбөр, төсөлийг санхүүжүүлэх			38919.8	20000.0	
14	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр					163839.1
15	Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох ажлын байр хадгалах хөтөлбөр					35440.0
	Дүн	525364.9	167831.1	576564.3	524105.9	746581.3

Зураг 13

Сангийн зарцуулалт /1 хүнд ногдох/



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаар үйлчлүүлсэн хүний тоо

Д/Д	Сангийн зарлагын зориулалт	2011	2012	2013	2014	2015
1	Иргэдэд ажил мэргэжлээ сонгох,мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт	2999	650	2244	2081	1953
2	Ажилд зуучлах	1581	403	1235	1375	1212
3	Нийтийг хамарсан ажил	1525	890	1153	470	440
4	Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ	143	32	19	23	29
5	Зээлийн хүүгийн нөхөн төлбөр	119	19	13	10	10
6	Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр			37	51	48
7	Хөдөлмөр эрхлэлтийн сургалт			458	203	
8	Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр			118	25	96
9	Ажил олоход хүндрэлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ			18	68	
10	Аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөр				116	
11	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих				55	52
12	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр				365	119
13	Бусад хөтөлбөр, төсөлийг санхүүлжүүлэх			89	20	
14	Хувиараа хөдөлмөр эрхлэгч,нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр					330
15	Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох ажлын байр хадгалах хөтөлбөр					144
	Дүн	6367	1994	5384	4862	4433

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, иргэдийг хөдөлмөрийн зах зээлийн эргэлтийг дэмжих, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, ажилд зуучлах, хөдөлмөрт бэлтгэх, малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих, нийтийг хамарсан ажил зохион байгуулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр,хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл,хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр,хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох ажлын байр хадгалах хөтөлбөрүүдийг санхүүлжүүлэхэд 746581.3 мянган төгрөг зарцуулагдаж, 4433 хүн хамарагдсан байна.


Хүснэгт 22

Д/Д	Сангийн зарлагын зориулалт	Нэг хүнд ногдох /мян.төг/				
		2011	2012	2013	2014	2015
1	Иргэдэд ажил мэргэжлээ сонгох,мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт	28.4	11.9	3.9	4.7	6.9
2	Ажилд зуучлах	5.6	5.4	1.8	4.2	5.0
3	Нийтийг хамарсан ажил	135.4	147.6	132.7	243.0	183.5
4	Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ	1492.0	773.7	1719.6	1859.0	2352.0
5	Зээлийн хүүгийн нөхөн төлбөр			200.7	173.5	189.9
6	Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр			225.5	12.7	10.0
7	Хөдөлмөр эрхлэлтийн сургалт			176.3	246.4	
8	Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр			2102.3	5000.0	2508.8
9	Ажил олоход хүндрэлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ			72.3	294.1	
10	Аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөр				271.7	
11	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих				541.8	811.5
12	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр				200.0	785.3
13	Бусад хөтөлбөр, төсөлийг санхүүлжүүлэх			437.3	1000.0	
14	Хувиараа хөдөлмөр эрхлэгч,нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр					496.5
15	Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох ажлын байр хадгалах хөтөлбөр					246.1
Дүн		82.5	84.2	107.1	107.8	168.4

Дээрхи сангийн зарцуулалтаас үзэхэд хамрагдсан нэг иргэнд ажил мэргэжлээ сонгох, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд зориулж 6.9 мянган төгрөг, ажилд зуучлахад 5.0 мянган төгрөг, нийтийг хамарсан ажилд хамрагдсан хүмүүст зориулж 183.5 мянган төгрөг, зээлийн хүүгийн нөхөн төлөх хөтөлбөрт 189.9 мянган төгрөг,ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд зориулж 2352.0 мянган төгрөг, хөдөлмөрт бэлтгэхэд зориулан 10.0 мянган төгрөг, малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжихэд зориулан 2508.8 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр 811.5 мянган төгрөг,залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 785.3 мянган төгрөг, хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл,хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөрт 496.5 мянган төгрөг,хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох ажлын байр хадгалах хөтөлбөрт 246.1 мянган тус тус зарцуулсан байна.

Зураг 14

Үйлчлүүлсэн хүний тоо



Дүгнэлт

1. Майнай аймаг 2013-2014 онуудад ажиллах хүчнийхээ 57.4-57.5 хувийг ашиглаж байсан бол 2015 онд 55.0 хувийг ашиглаж өмнөх онуудаас 2.4-2.5 пунктээр буурсан байна.
2. Сүүлийн жилүүдэд хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэр, бөөний худалдаа, зочид буудал зоогийн газар, боловсролын салбарт ажил эрхлэгчдийн тоо нэмэгдэж байна.
3. Хөдөлмөрийн насны суралцагчдын 46.2 хувь нь эрэгтэйчүүд, 53.8 хувь нь эмэгтэйчүүд байгаа ба хувийн жингээр эмэгтэйчүүд давамгайлж байна.
4. Аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн 60.3 хувь 16-34 насны залуучууд байна.
5. 2015 онд хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор орон нутагт 5 төрлийн хөтөлбөр болон нийтийг хамарсан ажлыг иргэдэд ил тод сурталчлан мэдээ, мэдээллээр хангаж, хэрэгцээ, шаардлагатай иргэд, аж ахуйн нэгжид хүргэж ажиллах үүний үр дүнд ажилгүйдлийг бууруулах, иргэдийг ажлын байраар хангах, цалинтай, орлоготой болгож амьжиргаагийн дээшлүүлэх зорилтыг дэвшүүлэн ажилласан бөгөөд хөтөлбөрийн хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэл болон өөрөө өөртөө ажлын байр бий болгох иргэдийн санал, санаачлагад тулгуурлан хөдөлмөр эрхлэлтийн бодлого хэрэгжүүлэгдэв.
6. Залуучууд, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр нь мэргэжлийн сургалт төгсөгч залуучуудын өөрсдэд зориулсан хөтөлбөр болохоор сайн ойлгож, хөдөлмөрлөх идэвх санаачлага нь дээшилж, давтан сургалтанд хамрагдаж, багаа бүрдүүлэн /3-5 хүүн нэг баг/ ажиллах хүсэл эрмэлзэлтэй болсон.
7. Уг хөтөлбөрийн үр дүнгээр 2015 онд авто засвар, үсчин, оёдолын чиглэлээр 3 бүлэг ажлын байр шинээр үйл ажиллагаагаа явуулж байна.
8. 2015 онд Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох ажлын байр хадгалах хөтөлбөрүүд шинээр хэрэгжиж 561 хүн хамарагдсан байна.
9. Ажилгүйчүүдийн 37.5 хувь нь дээд болон мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байгаа ба залуучуудын ажиллах нөхцөлийг бүрдүүлж зуучлах байгууллагуудтай хамтран ажил зохиох.

Ашигласан ном, материалууд

1. Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2011, 2012, 2013, 2014, 2015 он
2. Хүн амын ажил эрхлэлтийн дотоод мэдээлэл 2011-2015 он
3. Баян-Өлгий аймгийн эдийн засаг нийгмийн байдлын эмхтгэл 2011, 2012, 2013, 2014, 2015 он
4. Хөдөлмөр эрхлэлтийн албаны 2011, 2012, 2013, 2014, 2015 оны ажлын тайлан
5. Ажиллах хүчний судалгааны 2015 оны үр дүнгийн тайлан
6. Статистик мэдээллийн нэгдсэн сан: www.1212.mn